СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** СБА-2023/84/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Баруун-Урт сум<br>2023 он | Дарга,<br>тэргүүлэх аудитор: М.Нарантуяа<br>Утас: 70518396<br>Аудитын менежер: Г.Даваа<br>Утас: 70512123<br>Ахлах аудитор: Н.Болдбаатар<br>Утас: 70512127 |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 5

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ 10

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........ 10

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ........ 10

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 10

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ........ 10

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 11

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ 12

**4.1 Ерөнхий зүйл** ........ 12

**4.2 Материаллаг байдал** ........ 12

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ........ 13

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** 13

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ........ 13

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ........ 13

**4.5.1 Завсрын аудитын талаар** ........ 13

**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ........ 14

**5.1 Төлбөрийн акт** ........ 14

**5.2 Зөвлөмж** ........ 14

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ 16


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

# 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2023.08.25 № 81

танай ____________-ны №______________-т

СҮХБААТАР АЙМГИЙН УУЛБАЯН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА У.ДАЙЧИНБАТ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ бүрийн өртөг, зардлыг шинэчлэн тооцож, үзүүлсэн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас 481.3 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Эрүүл мэндийн төвийн 2022 гүйцэтгэлийн төлөвлөгөөнд нийт 11 зорилт, 59 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж гүйцэтгэлээр 85.0 хувийн биелэлттэй хэрэгжүүлсэн байна. Аймгийн хөгжлийн сангаас 25.0 сая төгрөгийн суудлын приус-30 машиныг олгосон байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.НАРАНТУЯА

D:/Bichig hereg/2023/A4 toot

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **74,460,920.92** | **85,523,721.34** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 636,032.42 | 39,838,503.84 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 636,032.42 | 39,838,503.84 |
| **3121** | **Төгрөг** | 636,032.42 | 39,838,503.84 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 636,032.42 | 39,838,503.84 |
| **33** | **АВЛАГА** | 45,158,400.00 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 45,158,400.00 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 45,158,400.00 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 28,666,488.50 | 45,685,217.50 |
| **351** | **Түүхий эд материал** | 12,180,358.50 | 15,455,342.50 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 5,534,367.50 | 5,534,367.50 |
| 35130 | Эм боох материал | 6,645,991.00 | 9,920,975.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 15,821,130.00 | 29,484,875.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 655,000.00 | 735,375.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,321,950.00 | 24,252,000.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 275,000.00 | 600,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,030,000.00 | 1,888,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 539,180.00 | 2,009,500.00 |
| 35600 | Мал амьтад | 665,000.00 | 745,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **320,980,308.07** | **399,104,711.65** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 320,980,308.07 | 399,104,711.65 |
| **392** | **Биет хөрөнгө** | 312,198,308.07 | 390,322,711.65 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 266,248,513.33 | 266,248,513.33 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -19,138,507.80 | -24,922,823.88 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 27,200,000.00 | 52,200,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -15,866,666.76 | -21,233,333.46 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 115,224,411.20 | 174,594,885.20 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -72,113,472.71 | -83,715,560.19 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 12,391,296.50 | 24,691,296.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -12,177,630.00 | -12,233,630.04 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 17,791,064.23 | 23,791,064.23 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -7,360,699.92 | -9,097,700.04 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 8,782,000.00 | 8,782,000.00 |
| 39301 | Програм хангамж | 770,000.00 | 770,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -770,000.00 | -770,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 8,782,000.00 | 8,782,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **395,441,228.99** | **484,628,432.99** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **395,441,228.99** | **484,628,432.99** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 395,441,228.99 | 484,628,432.99 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 378,017,703.51 | 378,017,703.51 |
| 51101 | Өмч: - төрийн | 378,017,703.51 | 378,017,703.51 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,171,452.94 | 90,358,656.94 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,171,452.94 | 1,171,452.94 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 89,187,204.00 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 16,252,072.54 | 16,252,072.54 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **395,441,228.99** | **484,628,432.99** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **649,017,793.39** | **591,138,254.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **96,821,082.39** | **81,513,134.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 96,821,082.39 | 81,513,134.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 96,821,082.39 | 81,513,134.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 8,474,100.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 96,821,082.39 | 73,039,034.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **200,500,811.00** | **509,625,120.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 351,695,900.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 123,836,781.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 123,343,981.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 492,800.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 18,407,300.00 | 28,340,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 18,407,300.00 | 28,340,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 58,256,730.00 | 481,285,120.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 58,256,730.00 | 481,285,120.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **529,892,720.40** | **501,951,050.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **529,892,720.40** | **501,951,050.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 503,414,517.40 | 501,949,673.82 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 315,826,791.58 | 305,539,256.72 |
| 210101 | Үндсэн цалин | 207,495,624.93 | 203,819,690.87 |
| 210102 | Нэмэгдэл | 76,327,893.43 | 72,245,821.60 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,784,000.00 | 3,770,000.00 |
| 210104 | Урамшуулал | 28,219,273.22 | 25,703,744.25 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43,400,473.00 | 41,572,016.86 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,007,773.00 | 29,932,407.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,780,600.00 | 2,839,880.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,296,800.00 | 2,272,425.03 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 574,100.00 | 550,654.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,741,200.00 | 5,976,648.78 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 13,369,567.00 | 16,985,623.82 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,336,509.00 | 4,059,327.82 |
| 210302 | Түлш, халаалт | 10,033,058.00 | 12,626,296.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 300,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,033,470.00 | 24,101,480.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 878,700.00 | 2,926,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,280,120.00 | 18,720,880.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,732,500.00 | 2,049,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 142,150.00 | 404,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 63,683,725.00 | 52,497,052.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 49,286,413.00 | 39,081,188.00 |
| 210502 | Хоол, хүнс | 14,397,312.00 | 13,415,864.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,345,950.00 | 26,974,727.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,985,300.00 | 14,254,827.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,360,650.00 | 12,719,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 195,000.00 | 472,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 195,000.00 | 472,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,287,403.00 | 2,379,737.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,287,403.00 | 2,379,737.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 34,272,137.82 | 31,427,780.42 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,285,725.50 | 6,881,710.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 15,986,412.32 | 24,546,070.42 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 26,478,203.00 | 1,376.18 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 26,400,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 26,400,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 78,203.00 | 1,376.18 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 78,203.00 | 1,376.18 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **119,125,072.99** | **89,187,204.00** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 27,227,280.60 | 00.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 27,227,280.60 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -27,227,280.60 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **91,897,792.39** | **89,187,204.00** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **507,038,311.00** | **563,257,620.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **8,474,100.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 8,474,100.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 8,474,100.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 8,474,100.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **507,038,311.00** | **554,783,520.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 351,695,900.00 | 00.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 123,836,781.00 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 123,343,981.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 492,800.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 18,407,300.00 | 28,340,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 18,407,300.00 | 28,340,000.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 13,098,330.00 | 526,443,520.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 13,098,330.00 | 526,443,520.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **506,402,278.58** | **491,232,448.58** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **506,402,278.58** | **491,232,448.58** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **479,924,075.58** | **491,231,072.40** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 315,826,791.58 | 305,539,256.72 |
| 210101 | Үндсэн цалин | 207,495,624.93 | 203,819,690.87 |
| 210102 | Нэмэгдэл | 76,327,893.43 | 72,245,821.60 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 3,784,000.00 | 3,770,000.00 |
| 210104 | Урамшуулал | 28,219,273.22 | 25,703,744.25 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43,400,473.00 | 41,572,016.86 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,007,773.00 | 29,932,407.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,780,600.00 | 2,839,880.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,296,800.00 | 2,272,425.03 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 574,100.00 | 550,654.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,741,200.00 | 5,976,648.78 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 13,369,567.00 | 17,843,623.82 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,336,509.00 | 4,059,327.82 |
| 210302 | Түлш, халаалт | 10,033,058.00 | 13,484,296.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 300,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 14,033,470.00 | 24,172,855.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 878,700.00 | 2,997,875.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,280,120.00 | 18,720,880.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,732,500.00 | 2,049,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 142,150.00 | 404,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 60,859,502.00 | 58,134,956.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 48,212,080.00 | 41,037,890.00 |
| 210502 | Хоол, хүнс | 12,647,422.00 | 15,897,066.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 1,200,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,696,330.00 | 30,620,364.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 736,800.00 | 17,335,064.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,959,530.00 | 13,285,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 195,000.00 | 472,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 195,000.00 | 472,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 12,287,403.00 | 5,839,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 12,287,403.00 | 5,839,800.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 14,255,539.00 | 7,036,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,255,539.00 | 7,036,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **26,478,203.00** | **1,376.18** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 26,400,000.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 26,400,000.00 | 00.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 78,203.00 | 1,376.18 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 78,203.00 | 1,376.18 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **636,032.42** | **72,025,171.42** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **32,822,700.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **32,822,700.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 32,822,700.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 32,822,700.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-32,822,700.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 636,032.42 | 39,202,471.42 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 636,032.42 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 636,032.42 | 39,838,503.84 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| **Код** | **Үзүүлэлт** | **Засгийн газрын оруулсан капитал** | **Дахин үнэлгээний нөөц** | **Хуримтлагдсан дүн** | **Засгийн газрын хувь оролцооны нийт дүн** |
|---|---|---|---|---|---|
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **378,017,703.51** | **16,252,072.54** | **1,171,452.94** | 395,441,228.99 |
| D01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **378,017,703.51** | **16,252,072.54** | **1,171,452.94** | 395,441,228.99 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **378,017,703.51** | **16,252,072.54** | **1,171,452.94** | 395,441,228.99 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 89,187,204.00 | 89,187,204.00 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **378,017,703.51** | **16,252,072.54** | **90,358,656.94** | 484,628,432.99 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 689,713,500.00 | 524,053,772.40 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 689,713,500.00 | 524,053,772.40 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 689,713,500.00 | 524,053,772.40 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 442,353,600.00 | 305,539,256.72 |
| 210101 | Үндсэн цалин | 277,809,700.00 | 203,819,690.87 |
| 210102 | Нэмэгдэл | 126,940,300.00 | 72,245,821.60 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 7,360,000.00 | 3,770,000.00 |
| 210104 | Урамшуулал | 30,243,600.00 | 25,703,744.25 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 56,210,500.00 | 41,572,016.86 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 38,243,600.00 | 29,932,407.91 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,645,600.00 | 2,839,880.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,552,400.00 | 2,272,425.03 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 888,100.00 | 550,654.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,880,800.00 | 5,976,648.78 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 20,600,000.00 | 18,843,623.82 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,000,000.00 | 4,059,327.82 |
| 210302 | Түлш, халаалт | 15,000,000.00 | 14,484,296.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,600,000.00 | 300,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 33,003,600.00 | 24,172,855.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,042,600.00 | 2,997,875.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 27,364,100.00 | 18,720,880.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,120,300.00 | 2,049,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 476,600.00 | 404,600.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 58,859,200.00 | 58,134,956.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 41,162,200.00 | 41,037,890.00 |
| 210502 | Хоол, хүнс | 16,493,600.00 | 15,897,066.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,203,400.00 | 1,200,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 54,741,200.00 | 53,118,064.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 32,951,800.00 | 31,332,764.00 |
| 210604 | Урсгал засвар | 21,789,400.00 | 21,785,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 747,900.00 | 472,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 747,900.00 | 472,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 16,158,200.00 | 15,164,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 10,863,200.00 | 10,669,800.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,295,000.00 | 4,495,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7039300.00 | 7036200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,039,300.00 | 7,036,200.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 689,713,500.00 | 563,388,243.82 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 30,895,000.00 | 28,338,623.82 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 30,895,000.00 | 28,338,623.82 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 586,076,600.00 | 535,049,620.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 586,076,600.00 | 535,049,620.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 72,741,900.00 | 00.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 72,741,900.00 | 00.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 636,032.42 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 39,838,503.84 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Эрүүл мэндийн төв нь “Хүн амд эмнэлгийн тусламжийг жигд хүртээмжтэй, чанарын өндөр түвшинд гүйцэтгэхийг эрхэмлэнэ” гэсэн эрхэм зорилготой байна.
Зорилт: Мэргэшсэн боловсон хүчнээр хангагдаж тэдний ололт амжилтаар дамжуулан дэвшилтэт технологи, техник төхөөрөмжийг эмчилгээ, оношилгоонд нэвтрүүлж бүсийн сум дунд эмнэлэг болох зорилтыг дэвшүүлжээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 01 дүгээр тогтоол “Жагсаалт, төлбөрийн хэмжээ,төлбөрийн арга, журам шинэчлэн батлах журам”
- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 06 дүгээр тогтоол “Багц,төлбөрийн хэмжээ,журам батлах тухай”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд зэрэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Эрүүл мэндийн төв нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 89,187.2 мянган төгрөгөөр буюу 23 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 636.0 | 39,838.5 | 39,202.5 |
| Авлага | 45,158.4 | - | -45,158.4 |
| Бараа материал | 28,666.5 | 45,685.2 | 17,018.7 |
| Үндсэн хөрөнгө | 320,980.3 | 399,104.7 | 78,124.4 |
| **Нийт хөрөнгө** | **395,441.2** | **484,628.4** | **89,187.2** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 395,441.2 | **484,628.4** | 89,187.2 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | 395,441.2 | **484,628.4** | **89,187.2** |

- *Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 39,202.5 мянган төгрөгөөр өссөн нь ЭМД-ын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн үлдэгдэл байна.*
- *Авлагын данс 45,158.5 мянган төгрөгөөр буурссан нь өмнөх оны эрүүл мэндийн даатгалын сангаас авах авлага барагдсан нь нөлөөлсөн байна*
- *Үндсэн хөрөнгө данс* 399,104.7 *мянган төгрөг болж* 78,124.4 *мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 32,822.7 мянга, хандиваар 69,847.8 мянга нийт 102,670.5 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнтэй холбоотой байна.*
- *Засгийн газрын хувь оролцоо данс* 89,187.2 *мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.*

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Эрүүл мэндийн салбарын төсвийн төсөл боловсруулах процесс өөрчлөгдөж ЭМДС-ийн санхүүжилтийг Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 01, 05 дугаар тогтоолын дагуу хүн амын тоо, насны ангилал, хүйс, хот хоорондын зайнаас хамааруулж нэг иргэнд ноогдох норматив зардал, үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээний санхүүжилтийг тухайн жилийн тоон үзүүлэлтэд тулгуулан төсвийн төслийг боловсруулдаг.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг ЭМДС-аас санхүүжилт 658,818.5 мянга, орон нутгийн санхүүжилт 30,895.0 мянга нийт 689,713.5 мянган төгрөгөөр төсөв батлагдсанаас 524,185.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулжээ.

Гүйцэтгэлээр харилцах дансны эхний үлдэгдэл 636.0 мянга, ЭМД-ийн сангаас 526,443.5 мянга, орон нутгийн санхүүжилт 28,338.6 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 8,474.0 мянга нийт 563,256.1 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн санхүүжилтээс 1.4

мянган төгрөгийг төвлөрүүлсэн бөгөөд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 39,838.5 мянган төгрөг байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 524,185.8 мянган төгрөг буюу 88 хувьтай зарцуулсан байна

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80302-Нэг иргэнд ногдох нормативаар тооцсон | 177,525.0 | 153,276.2 | 24,248.8 | 86% |
| 2 | 81603-Үндсэн мэргэжлийн тусламж | 312,989.0 | 310,184.8 | 2,804.2 | 99% |
| 3 | 83603-Нэмэлт-дээд шатны төсвөөс хуваарилсан | 72,741.9 | 71,588.6 | 1,153.3 | 98% |
| НИЙТ | | 563,256.1 | 524,185.7 | 39,070.4 | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### *3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр төлөвлөөгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Болдбаатар, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Эрүүл мэндийн төвийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн № 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын 529,892.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,948.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1[1], 15,2.3[2]-т зардлын хэмнэсэн эсэхийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулахад байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд 4,474.1 мянга, тээвэр шатахууны зардал 7.440.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Дээрх зардлууд өмнөх оноос нэмэгдсэн учир шалтгааныг авч үзвэл:

- *Дээрх зардлууд өсөхөд тээвэр шатахууны зардал өмнөх оноос 50 хувиар өссөн нь нөлөөлсөн байна.*

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд гарсан Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий бүхий 3 зарлагын гүйлгээ, урсгал санхүүжилтийн 21 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 6 шийдвэрийг мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 / тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;/ 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

*Шийдвэрлэсэн нь*: Шилэн дансны мэдээллийг хуульд заасан хугацаанд үнэн зөв, иж бүрэн олон нийтэд ойлгомжтой www.shilendans.gov.mn цахим хуудсанд бүрэн гүйцэт мэдээлж байх албан шаардлага өгсөн.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын завсрын аудит хийгээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

[1] байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээг хэмнэх;
[2] сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

*Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.*

*Хүснэгт 3 Албан* шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| **Төлбөрийн акт** | 2 | 4,100.0 | 2 | 4,100.0 | 100 |
| **Албан шаардлага** | 3 | 4,300.0 | 3 | 4,300.0 | 100 |
| **Зөвлөмж** | 3 | 45,200.0 | 3 | 45,200.0 | 100 |
| **Нийт дүн** | 8 | 53,200.0 | 8 | 53,200.0 | 100 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 42,177.3 мянган төгрөгийн зөрчил[3] илэрснээс, 1,177.3 мянган төгрөгийн төлбөрийн акт,шилэн дансны нэгдсэн сайтад мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлэх 1 албан шаардлага хүргүүлж, 4 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

5.1.1 Хувь хүний орлогын албан татвар 1,177.0 мянган төгрөгийг цалингаас суутгаж Татварын хэлтэс рүү дутуу шилжүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/, болон иж бүрэн, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

5.1.2 Цалингийн зардлаас урьдчилгаа олгоод суутган тооцоогүй шууд зардлаар илэрхийлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 /төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/, 41 дүгээр зүйлийн 41.2.3 /төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах;/, болон иж бүрэн, үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

### 5.2 Албан шаардлага

5.2.1 Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллээс таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий бүхий 3 зарлагын гүйлгээ, урсгал санхүүжилтийн 21 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 6 шийдвэрийг мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 / тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх;/ 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.3, 6.4 дэх заалтуудтай нийцэхгүй байна.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 1. Цахим худалдан авалттай холбоотой асуудал

[3] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*Илрүүлэлт:* Цахим дэлгүүрт байршсан эмийг худалдан авалгүйгээр бусад этгээдээс 41.0 сая төгрөгөөр худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.4 дэх "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно." заалттай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Цахим дэлгүүрт байгаа бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахгүй байх, Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах.

**2. Цахим худалдан аваттай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:*

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ." заасны дагуу хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлээгүй байна.

*Өгсөн зөвлөмж:*

Тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээ цахим дэлгүүрт байхгүй тохиолдолд холбогдох бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж ажиллах.

**3. Албан томилолттой холбоотой**

*Илрүүлэлт:* Албан томилолтыг удирдамж боловсруулаагүй төсөв захирагчийн тушаал шийдвэргүйгээр олгосон. Энэ нь Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 2.1 дэх /Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно./, 2.5 дахь "Албан томилолтоор ажиллах төрийн албан хаагчийн байр, хоол, унааны зардлын төсвийг байгууллагын эрх бүхий албан тушаалтан батална." заалттай нийцэхгүй байна.

*Өгсөн зөвлөмж*:

Албан томилолтыг анхан шатны баримтыг бүрдүүлж, холбогдох журмын дагуу олгож байх.

**4. Илүү цагийн хөлстэй холбоотой**

*Илрүүлэлт:* Эмч ажилчдад илүү цагийн хөлсийг олгохдоо зохих маягтыг хөтлөөгүй байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын 3.1 дэх / Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ" заалттай нийцэхгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*:

Илүү цагийн хөлсийг нэмэгдэл хөлс тооцож олгох хуудсыг үндэслэн олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Хувь хүний орлогын албан татварыг цалингаас суутгаж Татварын хэлтэс рүү дутуу шилжүүлсэн. | 1 | 1,777.0 | 1 | 1,177.0 | | | | | | | | |
| Цалингийн зардлаас урьдчилгаа олгоод суутган тооцоогүй шууд зардлаар илэрхийлсэн. | 1 | 0.3 | 1 | 0.3 | - | - | - | - | - | - | - | - |
| Албан томилолтыг удирдамж боловсруулаагүй төсөв захирагчийн тушаал шийдвэргүйгээр олгосон. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Эмч ажилчдад илүү цагийн хөлсийг олгохдоо зохих маягтыг хөтлөөгүй байна. | 1 | | | | | | 1 | | | | | |
| Дүн | 4 | 1,177.3 | 1 | 1,177.3 | - | - | 2 | - | - | - | - | - |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий бүхий 3 зарлагын гүйлгээ, урсгал санхүүжилтийн 21 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 6 шийдвэрийг мэдээлээгүй | 1 | - | - | - | 1 | - | - | - |
| **Дүн** | **1** | **-** | **-** | **-** | **1** | **-** | **-** | **-** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Цахим дэлгүүрт байгаа барааг бусад этгээдээс худалдан авсан | 1 | 41,000.0 | | | | | 1 | 41,000.0 |
| 10 саяас дээш өртөг бүхий барааг цахим дэлгүүрт байршуулах хүсэлт хүргүүлээгүй | 1 | | | | | | 1 | |
| **Дүн** | **2** | **41,000.0** | **-** | **-** | **-** | **-** | **2** | **41,000.0** |
| **Нийт дүн** | **3** | **41,000.0** | **-** | **-** | **1** | **-** | **2** | **41,000.0** |